

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.29 2019.08

Тамирхүү Окинава дахь сургалтанд оролцохоор Япон улсыг зорилоо! (2019.08.25)



Туслах ажилтан
Гэсэрийн хамт

Тамирхүү 2015 онд ослын улмаас хүзүү нуруу нугасны гэмтэлтэй болжээ. Ингээд суганаасаа доош мэдээгүй болж, тэргэнцэр хэрэглэх болсон байна. Мөр, тохойгоо хөдөлгөж чадах боловч хоёр гарын хуруунуудаа чөлөөтэй хөдөлгөх боломжгүй. Түүний үндсэн мэргэжил бол Байгаль орчны инженер. Монгол Улсын Их Сургуульд агаар, ус, хөрсний бохирдол, байгаль орчны чиглэлээр мэргэшиж, Тайландад мастер хамгаалжээ. Монголд ирснийхээ дараа хувийн хэвшилд ашигт малтмалын шинжилгээ хийдэг ажил хийж байсан боловч ослын улмаас ажлаасаа гарчээ. Ингээд хэсэг хугацааг гэртээ өнгөрүүлсэн байна. Энэ үед хамаатных нь хүн түүнд Бие даан амьдрах төвийг танилцуулсан бөгөөд “Байнга гэртээ байхаас дээр

байх...” гэж бодон очиж уулзсан байна. Тэгэхэд би өөртэйгээ адил хүзүүний гэмтэлтэй 6,7 хүмүүстэй уулзаж хөгжлийн бэрхшээлийн талаар ярилцсан. Одоо бодоход тэр бол Харилцан зөвлөлдөх (Peer counseling) үйл ажиллагаа байжээ. Тухайн үед би хэвтрийн байдалтайгаар тэргэнцэрээ хэрэглэдэг байсан бол надтай адил гэмтэлтэй хүмүүс сууж байсан нь сэтгэгдэл төрүүлсэн гэж байлаа. Тэрээр 2018 оны 11-р сараас Бие даан амьдрах төвд ажиллах болж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг хариуцаж байна. Саяхан нэг тархины саажилттай хүний гэрт нь очиж тэргэнцэр өгөх гэсэн боловч “Би гэрээсээ гарахыг хүсэхгүй байгаа учраас өөр хүнд өгсөн нь дээр байх аа” гэсэн татгалзсан хариу авчээ. Тэр хүн бүх амьдралаа гэртээ өнгөрөөсөн, сургуульд ч сураагүй хүн байсан. Үнэнийг хэлэхэд Монголд ийм хүмүүс маш олон бий. Эргэн тойрондоо төвөг учруулахыг хүсдэггүй юм уу, эсвэл өөрөө үнэхээр гарахыг хүсдэггүй юм уу...шалтгааныг нь сайн мэдэхгүй боловч яавал ийм хүмүүсийн бодлыг өөрчилж чадах вэ? Гадаад орнуудад энэ чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулдаг бол? Тэрээр 8-р сараас ЖАЙКА, Окинава төвд ХБИ-ийн Бие даан амьдрах эрх, Эрх мэдэлжүүлэлтийн талаар суралцахаар болсон. Туслах ажилтантайгаа хамт явах учраас санаа зовох зүйл байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлийн салбар бол миний хувьд шинэ салбар. Англи хэлний мэдлэгээ ашиглан Япон улс төдийгүй бусад орнуудын туршлагаас ч суралцахыг хүсэж байна. “Боловсрол бол ирээдүй рүү хөтлөх хаалга. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг дэмжин ажиллах нь миний мөрөөдөл” хэмээн Тамирхүү ярьж байв.

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) үр нөлөөтэй байна уу? (2019.08.30)

DET сургалт 2017 оны 2-р сараас зохион байгуулагдаж эхэлсэн бөгөөд 2019 оны 6-р сарын эцсийн байдлаар гол төлөв Улаанбаатар хотод нийт 262 удаа болж, давхардсан тоогоор 8381 хүн хамрагдаад байна. DET сургалтаар хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварт суурилсан ойлголтыг олж авах, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхийг зорилго болгодог. Хэдий тийм боловч бусад сургалт, семинар болоод DET сургалтын үр нөлөөг бодитойгоор тодорхойлох нь тийм ч хялбар зүйл биш. Жишээлбэл DET сургалтанд хамрагдсанаар оролцогчдын ойлголт өөрчлөгдөх, улмаар нийгэм болон байгууллага дотроо үйл ажиллагаа явуулахыг зорилго болгох хэдий ч энэ нь оролцогчдын хүрээлэн буй орчин зэргээс шалтгаалан харилцан адилгүй байх магадлалтай. Энэ мэт нарийн төвөгтэй байдлыг харгалзан үзэхийн сацуу DPUB төслийн зүгээс ХБХХЕГ-тай хамтран DET сургалтын Үнэлгээний ажлыг хийхээр болоод байна. Үнэлгээнд голчлон Хагас стандарт ярилцлага (semi-structured interview) -ын аргыг ашиглах бөгөөд DET сургалтанд хамрагдаж байсан хувь хүн, байгууллагаас ярилцлагын судалгаа авна. Үүнтэй холбогдуулан 8-р сард судлаачдыг сургах зэрэг бэлтгэл ажлуудыг хийлээ. Үнэлгээний ажлыг 9-р сараас эхлүүлэх бөгөөд үр дүн нь тодорхой болмогц та бүхэнд мэдээлэл хүргэн, тайлагнах болно.



Ярилцлагын судалгааны явцаас

Японы “Самрын үр” киноны тухай (2019.08.28)

Уржигдар Шинэ Монгол сургууль дээр Японы “Самрын үр” (Donguri no ie) киног үзүүллээ. Энэхүү кинонд сонсгол болон оюуны давхар бэрхшээлтэй хүүхдийн талаар гардаг бөгөөд 1970-аад оноос 1990-ээд он хүртэлх Японы хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн нөхцөл байдлын талаар өгүүлдэг. Тус киноны монгол хэлээрх хадмал орчуулгыг Шинэ Монгол сургуулийн төгсөгчид хийж, Монголчууддаа хүргэж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өсгөж байгаа эцэг эхийн бодит нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд болон тэдгээрийг даван гарч амьдралын утга учрыг олж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэдийг хүлээн авах нийгмийн өөрчлөлт зэрэг олон үйл явдлууд тус бүтээлд гарах учраас үзэгч бүр өөр өөрийнхөөрөө мэдэрч, хүлээж авах байх аа. Монголд ч гэсэн тусгай сургууль, ангиудаас гадна оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд өдрийн үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн байгууллага ч бий. Гэвч холбогдох боловсролын тогтолцоо, дэмжих тогтолцоо нь хараахан хангалттай хэмжээнд хүрээгүй байна. Түүнчлэн насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах байгууллага цөөн байгаа нь томоохон асуудал болж байгаа юм. “Самрын үр” кинонд эдгээр асуудлыг шийдвэрлэх үйл явц гарах бөгөөд одоогийн Монгол улсад тулгарч буй асуудлуудтай ижил төстэй зүйлүүд ч олон байна гэж бодлоо. Тус бүтээлийг илүү олон үзэгчдэд хүрээсэй хэмээн хүсэж байна.



JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **5405** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Мэдээллийн технологи ба хөгжлийн бэрхшээл



Ахлах зөвлөх Чибэ Хисао

Мэдээллийн хүртээмж болон мэдээллийн технологийн сургалт зохион байгуулах, 24 орны хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх зэргээр APCD нь олон үр дүнг гарган ажиллаж ирсэн. Нөгөөтэйгүүр эдгээрийн цаана асуудлууд ч байсан. Тэдгээрийн нэг нь мэдээллийн технологийн талаарх ойлголт нийгэмд дутмаг байсан явдал юм. Өнөө үед компьютер төдийгүй ухаалаг утас, таблет гэх мэт интернетийн хэрэглээ амьдралын зайлшгүй нэг хэрэгцээ болоод байна. Гэвч 2000-аад оны эхээр хөгжиж буй орнуудад интернетийн хэрэглээ тийм ч их түгээгүй байсан бөгөөд ухаалаг утас ч байгаагүй. Тухайн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч мэдээллийн технологи зайлшгүй хэрэгтэй! гэж ухуулж ярьж байсан ч ихэнх хүмүүс ойлгодоггүй байлаа. “Мэдээллийн технологи чухал хэдий ч хөгжиж буй орнуудын хувьд хараахан эртдэх зүйл. Үүнээс илүү чухал асуудлууд байна” гэх хариултыг очсон газар бүрээсээ авч байлаа. Мэдээжийн хэрэг бусад асуудлууд ч чухал. Гэхдээ мэдээллийн технологийн хэрэглээ цаашид улам түгэх нь тодорхой, юу юунаас илүүтэйгээр мэдээллийн технологийн хэрэглээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралд өөрчлөлт авчирна гэдэгт итгэж байсан миний хувьд эргэн тойрныхны тэгж хүлээж авч байгаа нь харамсалтай санагдаж байв. Тэр үед намайг дэмжиж түлхэж өгсөн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байлаа. Ялангуяа харааны бэрхшээлтэй иргэд мэдээллийн технологийн боломжийг эртнээс анзаарч мэдсэн байсан бөгөөд “Энэ технологи чухал хэрэгтэй” гэсэн бат итгэл үнэмшилтэй байсан юм. Тэдэнтэй хамт үйл ажиллагаа явуулж байсан маань миний хувьд том туршлага болж чадсан.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com